



**ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙД, ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН САЙДЫН ХАМТАРСАН
ТУШААЛ**

2023 оны 12 дугаар сарын 15-ны өдөр

Дугаар А/441, А/192

Улаанбаатар хот

**ДААТГУУЛАГЧ, ХҮНИЙ ХӨДӨЛМӨРИЙН ЧАДВАР АЛДАЛТЫН ХУВЬ, ХУГАЦАА,
ШАЛТГААНЫГ МАГАДЛАХ, ХӨДӨЛМӨР ЗОХИЦУУЛАЛТ ХИЙХЭД БАРИМТЛАХ ӨВЧНИЙ
ЖАГСААЛТ БАТЛАХ ТУХАЙ**

Нийгмийн даатгалын ерөнхий хууль (шинэчилсэн найруулга)-ийн 43 дугаар зүйлийн 43.5 дахь хэсэг, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.7 дахь хэсэг, Хүний дархлал хомсдолын вирусын халдвар, дархлалын олдмол хомсдолоос сэргийлэх тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

- 1."Даатгуулагч, хүний хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацаа, шалтгааныг магадлах, хөдөлмөр зохицуулалт хийхэд баримтлах өвчний жагсаалт"-ыг хавсралтаар баталсугай.
- 2.Энэ тушаалыг мөрдөж ажиллахыг Эрүүл мэндийн магадлалын төв, салбар, орон нутгийн зөвлөл, эмнэлгийн байгууллагын Эмнэлэг хяналтын комисст тус тус үүрэг болгосугай.
- 3.Энэ тушаалыг хэрэгжүүлэх зорилгоор Эрүүл мэндийн магадлалын зөвлөл, Эмнэлэг хяналтын комисс, холбогдох эмч, мэргэжилтнүүдэд сургалт зохион байгуулах, мэргэжил арга зүйгээр хангах, даатгуулагч, хүнд мэдээлэл өгч, сурталчилж ажиллахыг Эрүүл мэндийн яамны Эмнэлгийн тусламж, үйлчилгээний газар /А.Өнөржаргал/, Нийгмийн даатгалын ерөнхий газар /Л.Мөнхзул/, Нийгмийн даатгалын ерөнхий газрын дэргэдэх Эрүүл мэндийн магадлалын төв зөвлөлд тус тус даалгасугай.
- 4.Өвчний жагсаалтаас хасагдсан эсхүл өөрчлөгдсөн өвчний заалтаар урьд нь хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацаа тогтоолгосон даатгуулагч, хүний хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацааг эрүүл мэндийн магадлалын зөвлөлийн шийдвэрийн хүчин төгөлдөр хугацааг дуусах хүртэл хугацаанд хэвээр үргэлжлүүлсүгэй.
- 5.Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Эрүүл мэндийн яамны Эмнэлэг тусламж, үйлчилгээний газар /А.Өнөржаргал/, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Нийгмийн даатгалын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар /Б.Батжаргал/- т тус тус даалгасугай.
- 6.Энэ тушаал батлагдсантай холбогдуулан Эрүүл мэндийн сайд, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2021 оны А/758, А/197 дугаар хамтарсан тушаалыг 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс хүчингүй болсонд тооцсугай.
- 7.Энэхүү тушаалыг 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн мөрдсүгэй.

ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙД С.ЧИНЗОРИГ

ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН САЙД Х.БУЛГАНТУЯА